



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/260

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/45 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVII.2.8-д Эрүүл мэндийн салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/-д батлагдсан 500000000 (Таван зуун сая) төгрөгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар тус баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100573

Аймгийн Засаг даргын 2019 оны 04
дүгээр сарын 02-ны өдрийн 4200 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРЫН ИХ ЗАСВАР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ӨВӨРХАНГАЙ/-ИЙН
ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /Мянган төг/
1	Эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын их засвар /Өвөрхангай, Богд сум/	30,000.0
2	Эрүүл мэндийн төвийн дээврийн засвар /Өвөрхангай, Өлзийт сум/	14,000.0
3	Эрүүл мэндийн төвд хагас автомат биохимийн анализатор /Өвөрхангай, Баянгол сум/	24,000.0
4	Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж /Өвөрхангай, Баянгол сум/	18,000.0
5	Багийн эмнэлэгт тоног төхөөрөмж /Өвөрхангай, Нарийнтээл сум, Баянтээг баг/	10,000.0
6	Сумын эрүүл мэндийн төвд нярайн дулаацуулагч ширээ /Өвөрхангай, Нарийнтээл сум/	20,000.0
7	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат /Өвөрхангай, 12 сум/	30,000.0
8	Сумдын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх /Өвөрхангай, 12 сум/	294,000.0
9	Багийн эмч нарыг компьютер, унаагаар хангах /мотоцикль/	60,000.0
	НИЙТ ДҮН	500,000.0